



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР

САНХҮҮГИЙН АУДИТЫН ТАЙЛАН

МОНГОЛРОСЦВЕТМЕТ ТӨҮГ-ЫН 2021 ОНЫ САНХҮҮГИЙН
ТАЙЛАНГИЙН АУДИТЫН ТАЙЛАН

АУДИТЫН КОД: АХГ-2022/54/НА-СТА-ТӨА

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг
дараах хаягаар авна уу.



Аудитын хоёрдугаар газрын захирал, тэргүүлэх аудитор
Ц.Наранчимэг
Утас: 261663 Цахим хаяг: naranchimegts@audit.gov.mn
Аудитын менежер: Д.Энхдалай
Утас: 261885 Цахим хаяг: enkhdalaid@audit.gov.mn
Аудитор: О.Баярмаа
Утас: 261740 Цахим хаяг: bayarmaao@audit.gov.mn
Аудитор: М.Лхагвасүрэн
Утас: 261740 Цахим хаяг: lkhagvasuren@audit.gov.mn

Улаанбаатар хот
2022 он

Агуулга

Агуулга.....	1
АУДИТЫН САНАЛ ДҮГНЭЛТ	3
2.Аудит хийсэн санхүүгийн тайлан.....	5
2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан	5
2.2 Аудит хийсэн орлогын дэлгэрэнгүй тайлан.....	6
2.3 Аудит хийсэн өмчийн өөрчлөлтийн тайлан.....	7
2.4 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан.....	8
2.5 Техник, эдийн засгийн үндсэн үзүүлэлт, зорилтот түвшний гүйцэтгэл	9
3. Аудитын тайлан.....	11
3.1 Ерөнхий зүйл.....	11
3.2 Дотоод хяналт.....	11
3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал	11
3.4 Материаллаг байдал	12
4. Санхүүгийн тайлангийн тодруулга	12
4.1 Байгууллагын үйл ажиллагаа.....	12
4.2 Байгууллагын үйл ажиллагаа явуулж буй эрх зүйн орчин.....	12
4.3 Нягтлан бодох бүртгэлийн бодлого	13
4.2.Техник, эдийн засгийн үзүүлэлт, зорилтот түвшний гүйцэтгэл.....	15
5. Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал.....	16
5.1 Шилэн дансны мэдээлэл.....	16
5.2 Бусад хууль тогтоомжийн хүрээнд.....	16
6. Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт	17
7. Дараагийн аудитаар анхаарах асуудал	17
8. Аудитын илрүүлэлт	17
8.1 Төлбөрийн акт.....	18
8.2 Албан шаардлага	18
9. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн нэгтгэл	20

Товчилсон үгийн жагсаалт

АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
ААНОАТ	Аж ахуй нэгжийн орлогын албан татвар
АМНАТ	Ашигт малтмалын нөөц ашигласны татвар
БНМАУ	Бүгд Найрамдах Монгол Ард Улс
ЗСБНХУ	Зөвлөлт Социалист Бүгд Найрамдах Холбоот Улс
НӨАТ	Нэмэгдсэн өртгийн албан татвар
ТӨБЗГ	Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газар
ТӨҮГ	Төрийн өмчит үйлдвэрийн газар
УБҮ	Уулын баяжуулах үйлдвэр
ХХОАТ	Хувь хүний орлогын албан татвар
ЭМНДШ	Эрүүл мэнд нийгмийн даатгалын шимтгэл



МОНГОЛПРОСЦВЕТМЕТ ТӨҮГ-ЫН
ЗАХИРАЛ Б.МӨНХБАТ ТАНАА

ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР

15160 Улаанбаатар хог, Чингэлтэй дүүрэг
Бага тойруу 3, Засгийн газрын IV байр
Утас:26-04-37, Факс:51-26-42-30
E-mail: info@audit.gov.mn

2022.03.15 № 07/587
танай _____-ны № _____-г

Аудитын санал дүгнэлт

Зөрчилгүй дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.8-д заасны дагуу Монголпросцветмет ТӨҮГ-ын 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, орлогын дэлгэрэнгүй, өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгуудад аудит хийлээ.

Монголпросцветмет ТӨҮГ-ын 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайланг Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандарт болон Санхүүгийн тайлагналын олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, шалгагдагч байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Асуудлыг онцолсон зүйл

Монголпросцветмет ТӨҮГ-ын эзэмшилд байсан асгатын мөнгөний ордны MV-000278, MV-008645, MV-004388, MV-008191 тоот тусгай зөвшөөрлийг Эрдэнэс Монгол ХХК-д шилжүүлсэн боловч тусгай зөвшөөрлийн хайгуулын хөрөнгийн дүн санхүүгийн тайланд бүртгэлтэй байна.

Аудитын гол асуудлууд

Бидний мэргэжлийн шийдлийн дагуу аудитын гол асуудалд тайлант үеийн санхүүгийн тайлангийн аудитад хамгийн их нөлөөтэй зүйлсийг тодруулах ба тэдгээрийг аудитын хүрээнд нэгтгэсэн байдлаар авч үзсэн болно.

Тайлант оны эдийн засгийн үндсэн үзүүлэлт, зорилтот түвшний орлогыг 179,166.4 сая төгрөгөөр, зардлыг 157,456.8 сая төгрөгөөр, цэвэр ашгийг 21,709.6 сая төгрөг байхаар баталсан байна.

Гүйцэтгэлээр 256,336.4 сая төгрөгийн орлого бүрдүүлж, 170,531.7 сая төгрөгийн зардал гарган 85,804.7 сая төгрөгийн ашигтай ажилласан байна.

Бусад мэдээлэл

Удирдлага бусад мэдээлэлтэй холбоотой үүрэг хариуцлагыг хүлээнэ. Тус байгууллагын гүйцэтгэлийн төлөвлөгөөнд жонш, төмөр, алтны чиглэлээр шинэ орд эдийн засгийн эргэлтэд оруулах, шинэ дэвшилтэд технологи нэвтрүүлэх, орд газрын нөөцийн хэмжээг нэмэгдүүлэх зэрэг чиглэлээр нийт 10 томоохон төсөл арга хэмжээ хэрэгжүүлэхээр төлөвлөснөөс 90 хувийн гүйцэтгэлтэй гэж тайлагнасан байна.

Санхүүгийн тайланд өгсөн бидний дүгнэлт бусад мэдээллийг хамраагүй ба үүнд ямар нэг төрлийн баталгаажуулах дүгнэлт гаргаагүй болно.

Удирдлага болон Засаглах эрх бүхий этгээдүүдийн санхүүгийн тайланд хүлээх үүрэг, хариуцлага

Удирдлага санхүүгийн тайланг Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Санхүүгийн тайлагналын олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт гэдэг нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гаргах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

АУДИТЫН ХОЁРДУГААР ГАЗРЫН
ЗАХИРАЛ, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Ц.НАРАНЧИМЭГ

2.Аудит хийсэн санхүүгийн тайлан

2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

Мөрийн дугаар	Үзүүлэлт	/төгрөгөөр/	
		2020 оны 12-р сарын 31	2021 оны 12-р сарын 31
1	Хөрөнгө		
1.1.	Эргэлтийн хөрөнгө		
1.1.1.	Мөнгө ба түүнтэй адилтгах хөрөнгө	30,886,893,535.86	66,490,536,778.16
1.1.2.	Дансны авлага	5,156,752,292.77	2,067,732,927.97
1.1.3.	Татвар, НДШ-ийн авлага	483,262,152.10	27,542,170,292.46
1.1.4.	Бусад авлага	3,606,952.18	45,335,716.47
1.1.5.	Бусад санхүүгийн хөрөнгө	-	6,942,747,570.31
1.1.6.	Бараа материал	41,855,687,473.79	63,250,844,498.01
1.1.7.	Урьдчилж төлсөн зардал/тооцоо	8,854,729,046.95	11,978,357,135.93
1.1.10.	Эргэлтийн хөрөнгийн дүн	87,240,931,453.65	178,317,724,919.31
1.2.	Эргэлтийн бус хөрөнгө		
1.2.1.	Үндсэн хөрөнгө	80,270,709,454.13	82,388,619,366.36
1.2.2.	Биет бус хөрөнгө	4,773,993,704.02	5,509,659,059.89
1.2.5.	Хайгуул ба үнэлгээний хөрөнгө	3,903,244,182.09	6,894,354,544.59
1.2.5.1	Хайгуул ба үнэлгээний хөрөнгийн хасагдуулаг	(207,912,537.47)	(207,912,537.47)
1.2.8.	Бусад эргэлтийн бус хөрөнгө	620,058,563.20	255,076,979.00
1.2.7.	Дуусаагүй барилга	1,439,278,908.22	10,790,327,462.74
1.2.20.	Эргэлтийн бус хөрөнгийн дүн	90,799,372,274.19	105,630,124,875.11
1.3.	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН	178,040,303,727.84	283,947,849,794.42
2	ӨР ТӨЛБӨР БА ЭЗЭМШИГЧДИЙН ӨМЧ		
2.1.	ӨР ТӨЛБӨР		
2.1.1.	БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР		
2.1.1.1.	Дансны өглөг	6,433,898,546.66	5,276,990,148.30
2.1.1.2.	Цалингийн өглөг	2,196,683,746.54	4,259,996,193.31
2.1.1.3.	Татварын өр	12,248,370,650.38	3,123,783.48
2.1.1.4.	НДШ-ийн өглөг	64,165,749.71	-
2.1.1.5.	Богино хугацаат зээл	7,400,000,000.00	-
2.1.1.8.	Урьдчилж орсон орлого	16,173,999,282.35	60,216,511,698.99
2.1.1.9.	Нөөц / өр төлбөр /	1,461,813,423.96	1,097,222,007.06
2.1.1.10.	Бусад богино хугацаат өр төлбөр	3,733,837.69	5,390,975.73
2.1.1.20	БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨРИЙН ДҮН	45,982,665,237.29	70,859,234,806.87
2.1.2.	Урт хугацаат өр төлбөр		
2.1.2.3.	Хойшлогдсон татварын өр	154,581,346.62	202,007,742.30
2.1.2.20	Урт хугацаат өр төлбөрийн дүн	154,581,346.62	202,007,742.30
2.2.20.	Өр төлбөрийн нийт дүн	46,137,246,583.91	71,061,242,549.17
2.3.	2. Эзэмшигчдийн өмч		
2.3.1.	а) Төрийн өмч	1,226,788,000.00	1,226,788,000.00
2.3.4.	Хувьцаат капиталын дүн	1,226,788,000.00	1,226,788,000.00
2.3.6.	Дахин үнэлгээний нөөц	52,657,728,803.97	52,657,728,803.97
2.3.8	Эзэмшигчдийн өмчийн бусад хэсэг	2,641,413,040.00	2,641,413,040.00
2.3.9	Тусгай зориулалтын нөөц сан	17,500,000,000.00	18,100,000,000.00
2.3.10	Хуримтлагдсан ашиг (алдагдал)	57,877,127,299.96	138,260,677,401.28
2.3.10.1	Тайлангийн үеийн	48,211,710,113.37	85,204,721,111.32

2.3.10.2	Өмнөх үеийн	9,665,417,186.59	53,055,956,289.96
2.3.20	Эзэмшигчдийн өмчийн дүн	131,903,057,143.93	212,886,607,245.25
2.5.20.	ӨР ТӨЛБӨР БА ЭЗЭМШИГЧИЙН ӨМЧИЙН ДҮН	178,040,303,727.84	283,947,849,794.42

2.2 Аудит хийсэн орлогын дэлгэрэнгүй тайлан

/төгрөгөөр/

Мөрийн дугаар	Үзүүлэлт	2020 оны 12-р сарын 31	2021 оны 12 сарын 31
1	Борлуулалтын орлого (цэвэр)	209,996,270,877.59	251,869,576,123.09
2	Борлуулалтын өртөг	100,354,859,527.80	88,469,326,418.14
3	Нийт ашиг (алдагдал)	109,641,411,349.79	163,400,249,704.95
4	Түрээсийн орлого	262,071,003.94	98,297,677.25
5	Хүүгийн орлого	48,888,920.06	968,792.76
8	Бусад орлого	16,101,245,285.78	5,992,606,823.48
9	Борлуулалт, маркетингийн зардал	27,634,609,852.23	32,311,163,537.91
10	Ерөнхий ба удирдлагын зардал	7,620,063,307.57	7,641,870,678.82
11	Санхүүгийн зардал	1,633,454,392.23	-
12	Бусад зардал	19,939,139,831.49	12,398,143,214.17
13	Гадаад валютын ханшийн зөрүүний олз (гарз)	(127,933,945.34)	(96,325,086.85)
14	Үндсэн хөрөнгө данснаас хассаны олз (гарз)	(56,419,698.83)	(396,488,523.48)
18	Татвар төлөхийн өмнөх ашиг (алдагдал)	69,041,995,531.88	116,648,131,957.21
19	Орлогын татварын зардал	20,830,285,418.51	30,843,410,845.89
20	Татварын дараах ашиг (алдагдал)	48,211,710,113.37	85,804,721,111.32
22	Тайлант үеийн цэвэр ашиг (алдагдал)	48,211,710,113.37	85,804,721,111.32
23.1	Хөрөнгийн дахин үнэлгээний нэмэгдлийн зөрүү	52,657,728,803.97	

2.3 Аудит хийсэн өмчийн өөрчлөлтийн тайлан

/төгрөгөөр/

№	Үзүүлэлт	Өмч	Хөрөнгийн дахин үнэлгээний нэмэгдэл	Эздийн өмчийн бусад хэсэг	Хуримтлагдсан ашиг	Нийт дүн
1	2019 оны 12-р сарын 31-ний үлдэгдэл	1,226,788,000.00	12,265,209,146.82	-	25,832,350,253.95	39,324,347,400.78
2	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлтийн нөлөө, алдааны залруулга					-
3	Залруулсан үлдэгдэл			-		
4	Тайлант үеийн цэвэр ашиг (алдагдал)				48,211,710,113.37	48,211,710,113.37
5	Бусад дэлгэрэнгүй орлого					-
6	Өмчид гаргасан өөрчлөлт		40,392,519,657.14	20,141,413,040.00	(11,000,000,000.00)	49,533,932,697.14
7	Зарласан ногдол ашиг				(5,166,933,067.36)	(5,166,933,067.36)
8	Дахин үнэлгээний нэмэгдлийн хэрэгжсэн дүн					-
9	2020 оны 12-р сарын 31-ний үлдэгдэл	1,226,788,000.00	52,657,728,803.96	20,141,413,040.00	57,877,127,299.96	131,903,057,143.93
10	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлтийн нөлөө, алдааны залруулга					-
11	Залруулсан үлдэгдэл					-
12	Тайлант үеийн цэвэр ашиг (алдагдал)				85,204,721,111.32	85,204,721,111.32
13	Бусад дэлгэрэнгүй орлого					-
14	Өмчид гаргасан өөрчлөлт				600,000,000.00	600,000,000.00
15	Ногдол ашиг				(4,821,171,010.00)	(4,821,171,010.00)
16	Дахин үнэлгээний нэмэгдлийн хэрэгжсэн дүн					-
17	2021 оны 12-р сарын 31-ний үлдэгдэл	1,226,788,000.00	52,657,728,803.96	20,141,413,040.00	138,860,677,401.28	212,886,607,245.25

2.4 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

/төгрөгөөр/

Мөрийн дугаар	ҮЗҮҮЛЭЛТ	2020 оны 12-р сарын 31	2021 оны 12-р сарын 31
1	Үндсэн үйл ажиллагааны мөнгөн гүйлгээ		
1.1	Мөнгөн орлогын дүн	216,246,307,173.67	314,056,148,754.43
1.1.1	Бараа борлуулсан, үйлчилгээ үзүүлсэний орлого	213,157,390,593.75	307,199,563,079.15
1.1.2	Эрхийн шимтгэл, хураамж, төлбөрийн орлого		-
1.1.3	Даатгалын нөхвөрөөс хүлээн авсан мөнгө	46,696,187.00	21,478,806.00
1.1.6	Бусад мөнгөн орлого	3,042,220,392.92	6,835,106,869.28
1.2	Мөнгөн зарлагын дүн	171,620,734,980.89	247,400,513,582.67
1.2.1	Ажиллагчдад төлсөн	37,898,023,907.64	41,285,090,831.00
1.2.2	Нийгмийн даатгалын байгууллагад төлсөн	11,293,257,391.23	12,736,090,645.80
1.2.3	Бараа материал худалдан авахад төлсөн	31,023,923,754.54	30,518,033,926.99
1.2.4	Ашиглалтын зардалд төлсөн	21,069,095,603.16	25,843,800,845.85
1.2.5	Түлш, шатахуун, тээврийн хөлс, сэлбэг хэрэгсэлд төлсөн	29,025,208,341.28	31,258,183,858.79
1.2.6	Хүүгийн төлбөрт төлсөн	1,633,454,392.23	-
1.2.7	Татварын байгууллагад төлсөн	38,023,671,190.82	99,210,924,276.73
1.2.8	Даатгалын төлбөрт төлсөн	85,752,476.00	135,929,707.00
1.2.9	Бусад мөнгөн зарлага	1,568,347,923.99	6,412,459,490.51
1.3	Үндсэн үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээний дүн	44,625,572,192.78	66,655,635,171.76
2	Хөрөнгө оруулалтын үйл ажиллагааны мөнгөн гүйлгээ		
2.1	Мөнгөн орлогын дүн	48,888,920.07	46,568,792.76
2.1.1	Үндсэн хөрөнгө борлуулсаны орлого		45,600,000.00
2.1.6	Хүлээн авсан хүүний орлого	48,888,920.07	968,792.76
2.2	Мөнгөн зарлагын дүн	7,514,213,450.10	18,774,246,163.82
2.2.1	Үндсэн хөрөнгө олж эзэмшихэд төлсөн	7,514,213,450.10	18,774,246,163.82
2.3	Хөрөнгө оруулалтын үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээний дүн	7,465,324,530.03	18,727,677,371.06
3	Санхүүгийн үйл ажиллагааны мөнгөн гүйлгээ		
3.1	Мөнгөн орлогын дүн	-	-
3.2	Мөнгөн зарлагын дүн	18,418,733,067.36	12,221,171,010.00
3.2.1	Зээл, өрийн үнэт цаасны төлбөрт төлсөн	13,251,800,000.00	7,400,000,000.00
3.2.4	Төлсөн ногдол ашиг	5,166,933,067.36	4,821,171,010.00
3.3	Санхүүгийн үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээний дүн	18,418,733,067.36	12,221,171,010.00
4	Валютын ханшийн зөрүү	546,887,406.63	(103,143,548.40)
5	Бүх цэвэр мөнгөн гүйлгээ	19,288,402,002.02	35,603,643,242.30
6	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	11,598,491,533.84	30,886,893,535.86
7	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	30,886,893,535.86	66,490,536,778.16

2.5 Техник, эдийн засгийн үндсэн үзүүлэлт, зорилтот түвшний гүйцэтгэл

д/д	Үзүүлэлтүүд	Хэмжих нэгж	2020 оны Гүйцэтгэл	2021 он			
				Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Хувь
1	Бүтээгдэхүүн үйлдвэрлэлт ба борлуулалт						
1.1	Бүтээгдэхүүн үйлдвэрлэлт						
	Хайлуур жоншны бүтээгдэхүүн үйлдвэрлэл	сая.тн	25.1	15.1	11.5	3.7	75.8
	Төмрийн баяжмалын бүтээгдэхүүн үйлдвэрлэл	сая.тн	649.2	393.8	672.5	(278.7)	170.8
	Алт олборлолт	кг	82.2	98.4	42.6	0.1	43.3
1.2	Бүтээгдэхүүн борлуулалт					0.0	
	Хайлуур жоншны бүтээгдэхүүний борлуулалт	сая.тн	19.5	15.1	12.7	2.5	83.7
	Төмрийн баяжмалын бүтээгдэхүүний борлуулалт	сая.тн	684.0	458.8	555.5	(96.7)	121.1
	Төмрийн хүдрийн борлуулалт	сая.тн	1,005.2	1,694.0	1,221.8	472.2	72.1
	Алтын борлуулалт	кг	82.2	98.4	42.6	0.1	43.3
2	Нийт борлуулалтын орлого	сая.төг	226,408.7	179,166.4	256,336.4	(77,170.1)	143.1
2.1	Үүнд: ФФ-95 флотацын баяжмалын борлуулалт	сая.төг	21,421.0	17,130.0	14,363.3	2,766.7	83.8
2.2	ФК-75 металлургийн баяжмалын борлуулалт	сая.төг	197.6	74.0	70.9	3.1	95.8
2.3	Ее-65 төмрийн нойтон баяжмалын борлуулалт	сая.төг	49,345.1	33,874.9	62,889.1	(29,014.1)	185.7
2.4	Ее-52 төмрийн хуурай баяжмалын борлуулалт	сая.төг	75,368.2	30,992.3	99,628.8	(68,636.5)	321.5
2.5	Төмрийн хүдрийн борлуулалт	сая.төг	49,719.5	74,964.0	66,293.5	8,670.5	88.4
2.6	Алтын борлуулалт	сая.төг	13,945.1	16,728.0	7,095.3	9,632.7	42.4
2.7	Бусад орлого	сая.төг	16,412.2	5,403.2	5,995.5	(592.4)	111.0
3	Нийт зардал	сая.төг	151,215.2	149,759.5	158,638.9	(8,879.4)	105.9
	Үүнээс: Удирдлагын зардал	сая.төг	7,577.0	9,046.2	7,641.9	1,404.3	84.5
	Нийгмийн хариуцлагын хүрээний зардал	сая.төг	4,552.6	5,953.2	5,231.3	721.9	87.9
4	Татварын өмнөх ашиг	сая.төг	69,042.9	26,927.0	116,600.6	(89,673.5)	433.0
5	Цэвэр ашиг	сая.төг	48,211.7	21,709.6	85,804.7	(64,095.1)	395.2
6	Төсөвт төлөх татвар, шимтгэл	сая.төг	58,360.5	34,842.5	77,679.4	(42,836.9)	222.9
6.1	Аж ахуй нэгжийн орлогын албан татвар	сая.төг	20,831.2	5,217.4	30,795.8	(25,578.4)	590.3
6.2	Нэмэгдсэн өртгийн албан татвар	сая.төг	3,511.1	5,051.4	7,434.4	(2,383.0)	147.2
6.3	АМНАТ	сая.төг	13,624.8	10,788.4	21,002.2	(10,213.9)	194.7
6.4	Ус ашигласны төлбөр	сая.төг	1,323.4	1,303.8	1,044.8	259.0	80.1
6.5	Газрын төлбөр	сая.төг	285.5	358.0	302.6	55.5	84.5
6.6	Галт зэвсгийн албан татвар	сая.төг	0.7	0.8	0.9	(0.1)	111.9
6.7	Агаарын бохирдлын төлбөр	сая.төг	3.3	1.4	2.8	(1.5)	208.4
6.8	Тээврийн хэрэгслийн татвар	сая.төг	31.8	31.4	20.6	10.8	65.6
6.9	Гадаадын ажиллах хүч	сая.төг	0.0	40.3		40.3	-

	ажиллуулсны татвар						
6.1	Нийгмийн даатгал, эрүүл мэндийн даатгалын шимтгэл	сая.төг	10,912.1	7,894.2	12,514.2	(4,619.9)	158.5
6.11	Үл хөдлөх хөрөнгийн татвар	сая.төг	78.1	189.4	193.7	(4.3)	102.3
6.12	ХХОАТ	сая.төг	4,131.7	3,966.0	4,310.6	(344.6)	108.7
6.13	Бусад татвар	сая.төг	3,626.7		56.9	(56.9)	
7	Ажиллагсдын дундаж хүний тоо	хүн	1,503	1,604	1,563	0.0	97.4
8	Цалингийн сан	сая.төг	45,271.6	52,937.2	49,219.8	3,717.4	93.0
9	Ажиллагсдын сарын дундаж цалин	сая.төг	2,510.6	2,750.3	2,624.2	126.1	95.4
10	Борлуулалтын 1 төгрөгт ногдох зардал	төг	0.65	0.81	0.51	0.0	63.0
11	Хөрөнгө оруулалт	сая.төг	8,797.3	47,869.7	23,855.6	24,014.1	49.8
12	Нийт авлага	сая.төг	5,643.6	1,791.5	2,067.7	(276.2)	115.4
13	Нийт өглөг	сая.төг	46,137.2	52,048.1	71,061.2	(19,013.1)	136.5
	Богино хугацаат өр төлбөр	сая.төг	45,982.7	40,812.6	70,859.2	(30,046.7)	173.6
	Урт хугацаат өр төлбөр	сая.төг	154.6	11,235.6	202.0	11,033.6	1.8

3. Аудитын тайлан

3.1 Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д “Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана” гэж заасны дагуу Монголросцветмет ТӨҮГ-ын 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайланд аудит аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд компанийн дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын талаар болон аудитын явцад илрүүлсэн алдаа, зөрчил, гаргасан шийдэл, анхаарал татахуйц бусад чухал асуудал болон аудитын санал дүгнэлт, түүний үндэслэлийг хураангуйлан толилуулав.

Аудитыг 2022 оны 01 дүгээр сарын 05-ны өдрөөс 2022 оны 03 дугаар сарын 15-ны хооронд Аудитын хоёрдугаар газрын аудитор М.Лхагвасүрэн, О.Баярмаа нар гүйцэтгэж, чанарын хяналтыг ахлах аудитор Б.Эрдэнэзул, аудитын менежер Д.Энхдалай, Захирал, Тэргүүлэх аудитор Ц.Наранчимэг нар хэрэгжүүлсэн.

Монголросцветмет ТӨҮГ-ын 2021 оны санхүүгийн тайланг Үндэсний аудитын газарт 2022 оны 01 дүгээр сарын 24-ний өдрийн 1/493 дугаар албан бичгээр ирүүлсэн байна.

3.2 Дотоод хяналт

Компанийн удирдлагын хэрэгжүүлж байгаа дотоод хяналтуудаас төлөвлөлтийн үе шатанд аудитад хамааралтай хяналтыг авч үзэж, гүйцэтгэх үе шатанд хяналтын сорил гүйцэтгэсний үр дүнд дотоод хяналтын үйл ажиллагааны зохион байгуулалт, хэрэгжилт үр нөлөөтэй байна гэж үзсэн.

Тус компанийн мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нь холбогдох хууль тогтоомж, нягтлан бодох бүртгэлийн стандартад нийцсэн, тус байгууллагын үйл ажиллагааны онцлогт тохирсон байна.

Дотоод хяналт, мониторингийн хэлтэс тайлант оны батлагдсан төлөвлөгөөний дагуу Шижир алтны үйлдвэр болон Бор-Өндөр УБҮ-ийн үйл ажиллагаа, худалдан авалтын гэрээ, цалин хөлс, хөрөнгийн хадгалалт хамгаалалт, шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт, авлага өглөг барагдуулалт болон ашиглагдахгүй байгаа үндсэн хөрөнгө, бараа материалын үлдэгдэлд дотоод аудит хийж зөвлөмж өгч хэрэгжилтэд хяналт тавин ажилласан байна.

Дотоод аудитын чиг үүрэг, түүний гүйцэтгэсэн ажлын найдвартай байдлын талаар ойлголт олж авснаар дотоод аудитын гүйцэтгэсэн ажлыг аудитад ашиглах, дотоод аудитораас шууд тусалцаа авах шаардлагагүй гэж үзлээ.

3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор санал дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино.

Монголросцветмет ТӨҮГ-ын 2021 оны санхүүгийн тайлан дахь ажил гүйлгээг аккрузал сууриар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн хүлээн зөвшөөрөхүйц санхүүгийн тайлагналын үзэл баримтлал гэж үнэлсэн.

3.4 Материаллаг байдал

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр 2020 оны санхүүгийн тайлан дахь үр дүнгийн тайлангийн зарлагыг сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэл дунд гэж үнэлэн материаллаг байдлын түвшнийг 1.5 хувиар тогтоов.

Төлөвлөлтийн материаллаг байдлыг 2020 оны үр дүнгийн тайлангийн 157,182.1 сая төгрөгөөс 1,5 хувиар буюу 2,357.7 сая төгрөгөөр тогтоосон.

Тогтоосон төлөвлөлтийн ерөнхий материаллаг байдлыг аудитын явцад дахин хянаж шинэчлэн тогтоох шаардлагагүй гэж үзсэн.

4. Санхүүгийн тайлангийн тодруулга

4.1 Байгууллагын үйл ажиллагаа

Монголросцветмет” ТӨҮГ-ын үндсэн зорилго нь “Уул уурхай, хайлуур жонш, алт болон бусад ашигт малтмал олборлох, баяжуулах, борлуулах чиглэлээр дэлхийд өрсөлдөхүйц, олон улсын жишигт хүрсэн засаглал, технологи, чадавх бүхий үйлдвэр болох, эцсийн бүтээгдэхүүн үйлдвэрлэх замаар Монгол Улсын эдийн засгийн өсөлтийг дэмжих” гэж тодорхойлжээ.

Байгууллагын дүрмийг засгийн газрын 2019 оны 103 дугаар тогтоолоор шинэчлэн баталж үйл ажиллагааны чиглэлийг дараах байдлаар тодорхойлжээ. Үүнд:

- Хайлуур жонш, алт болон бусад ашигт малтмал олборлох, баяжуулах, борлуулах;
- Баяжмал болон бусад бэлэн бүтээгдэхүүн үйлдвэрлэх, борлуулах;
- Үйлдвэрлэсэн баяжмалыг металлургийн аргаар боловсруулах;
- Монгол Улсын нутаг дэвсгэр дээр геологи хайгуулын ажил, явуулах ашигт малтмалын орд газрыг үйлдвэрлэлийн аргаар эзэмшихэд бэлтгэх, ашиглах;
- Барилгын зураг төслийн ажил хийх, барилга байгууламж угсралт, монтаж, тохируулгын ажил гүйцэтгэх;
- Гадаадад бүтээгдэхүүнээ экспортлох, аж ахуйн үйл ажиллагаа явуулахад шаардлагатай материал, техник төхөөрөмж импортлох;
- Дотоод гадаадын үйлдвэр, аж ахуйн нэгж, байгууллагатай гэрээ, хэлэлцээр байгуулж, гэрээний нөхцөлийн дагуу тэдэнд зөвлөх болон бусад төрлийн үйлчилгээ үзүүлэх;
- Үйлдвэрийн газар нь үндсэн болон хууль тогтоомжоор хориглоогүй бусад чиг үүргийг хэрэгжүүлэхэд чиглэгдсэн бизнесийн үйл ажиллагаа эрхэлж болно.

Байгууллагын улсын бүртгэлийн гэрчилгээнд “Аж ахуйн тооцоотой үйлдвэрийн газар” гэсэн хариуцлагын хэлбэртэй байна. Өмчийг 100 хувь төр эзэмшиж байна.

4.2 Байгууллагын үйл ажиллагаа явуулж буй эрх зүйн орчин

Монголросцветмет ТӨҮГ нь БНМАУ болон ЗСБНХУ-ын Засгийн газар хоорондын 1973 оны 2 дугаар сарын 24-ний өдрийн хэлэлцээрийн үр дүнд БНМАУ-ын нутаг дэвсгэр дээр хайлуур жоншны хүдэр, алт олборлох, уурхайн геологи-хайгуулын ажил гүйцэтгэх, барилга угсралт, эрдэм шинжилгээ, төсөл хайгуулын ажил явуулах зорилгоор байгуулагдсан хуулийн этгээд юм. Монгол Улсын Засгийн газар, Оросын Холбооны Улсын Засгийн газар хооронд 2007 оны 4 дүгээр сарын 25-ны өдөр шинэчлэн байгуулсан Засгийн газар хоорондын хэлэлцээрийн 1 дүгээр зүйлээр Хамтарсан нэгдэл

гэсэн статусыг Хязгаарлагдмал Хариуцлагатай Компани болгон өөрчилсөн. Монгол Улсын Засгийн газрын 2019 оны 3 дугаар сарын 21-ний 103 дугаар тогтоолоор Монголросцветмет ТӨҮГ болсон байна.

Засгийн газрын 2021 оны “Төсвийн хэмнэлтийн талаар авах арга хэмжээний тухай” 43 дугаар тогтоолын 1.3. “Төрийн болон орон нутгийн өмчит, тэдгээрийн оролцоотой аж ахуйн нэгж, байгууллагын дотоод зохион байгуулалтын бүтэц, чиг үүргийг оновчтой тодорхойлж, орон тоо, чиг үүргийн давхардлыг арилгаж, төсөв, зардлыг хэмнэсэн байхаар шинэчлэх, удирдлагын цалин хөлсийг орлого, үр ашигтай нь уялдуулан, үйл ажиллагааны чиглэл, цар хүрээ, түвшин зэргийг харгалзан нэг хэлбэр, нийтлэг жишгээр ангилан тогтоодог зарчимд шилжих, цалин хөлсийг нэмэгдүүлэхгүй, шагнал, урамшуулал олгохгүй байх, зочин төлөөлөгч хүлээн авах, бэлэг дурсгал (цүнх, календарь, мэндчилгээ г.м)-ын зардлыг гаргахгүй байх;”-д заасны дагуу чиг үүргийн давхардлыг арилгаж орон тоог 41 ажиллагсдаар бууруулсан, удирдлагын цалин хөлсийг орлого, үр ашигтай нь уялдуулан 5,579.6 сая төгрөгөөр тогтоож, томилолтын зардлыг 56.1 сая, бичиг хэргийн зардлыг 3.8 сая төгрөгөөр хэмнэсэн байна.

Тайлант хугацаанд байгууллагын санхүүгийн үйл ажиллагаанд мөрддөг хууль, тогтоомж, бодлого, журамд дараах өөрчлөлтүүд орсон байна. Үүнд:

- Нийгмийн даатгалын тухай хуулийн 15 дугаар зүйлд заасан хувь хэмжээнд 2021 оны 6 дугаар сарын 11-ний өдрийн хуулиар өөрчлөлт орсон.
- Засгийн газрын 2021 оны 06 дугаар сарын 23-ны өдрийн 174 дугаар тогтоолоор ашигт малтмалын нөөц ашигласны төлбөр тооцох үнэлгээний аргачлалыг шинэчлэн баталсан.
- Засгийн газрын 2021 оны 124 дүгээр тогтоол “Босго үнэ шинэчлэн батлах тухай хуульд өөрчлөлт орсон.
- Засгийн газрын 2021 оны 43 дугаар тогтоол “Төсвийн хэмнэлтийн талаар авах арга хэмжээний тухай” батлагдсан.

4.3 Нягтлан бодох бүртгэлийн бодлого

Монголросцветмет ТӨҮГ-ын санхүүгийн тайлангууд нь Нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын зөвлөлөөс баталсан Санхүүгийн тайлагналын олон улсын стандартын дагуу бэлтгэгдсэн байна.

Тус байгууллагын 2021 оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 105,907.5 сая төгрөгөөр буюу 59.5 хувиар өссөн нь мөнгөн хөрөнгө, авлага, бараа материал, үндсэн хөрөнгө, өр төлбөр, хуримтлагдсан үр дүнгийн данснуудад материаллаг өөрчлөлт гарсан байна.

Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	/мянган төгрөг/
			Өөрчлөлт
Б	1	2	3=2-1
Мөнгөн хөрөнгө	30,886,893.5	66,490,536.8	35,603,643.3
Авлага	5,643,621.4	29,655,238.9	24,011,617.5
Урьдчилж гарсан зардал/тооцоо	8,854,729.0	11,978,357.1	3,123,628.1
Бусад санхүүгийн хөрөнгө	-	6,942,747.6	6,942,747.6
Бараа материал	41,855,687.5	63,250,844.5	21,395,157.0
Биет хөрөнгө	81,709,988.4	93,178,946.9	11,468,958.5
Биет бус хөрөнгө	4,773,993.7	5,509,659.0	735,665.3

Бусад хөрөнгө	4,315,390.2	6,941,519.0	2,626,128.8
Нийт хөрөнгө	178,040,303.7	283,947,849.8	105,907,546.1
Өр төлбөр	46,137,246.6	71,061,242.6	24,923,996.0
Төрийн өмч	1,226,788.0	1,226,788.0	-
Өмнөх үеийн үр дүн	9,665,417.2	53,055,956.3	43,390,539.1
Тайлант үеийн үр дүн	48,211,710.1	85,204,721.1	36,993,011.0
Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	52,657,728.8	52,657,728.8	-
Эздийн өмчийн бусад хэсэг	2,641,413.0	2,641,413.0	-
Нөөцийн сан	17,500,000.0	18,100,000.0	600,000.0
Нийт өр төлбөр ба цэвэр хөрөнгө өмчийн дүн	178,040,303.7	283,947,849.8	105,907,546.1

Дансны үлдэгдэлд гарсан материаллаг дүнтэй дараах өөрчлөлтүүд байна. Үүнд:

- Мөнгөн хөрөнгийн дансны үлдэгдэл өмнөх оноос 35,603.6 сая төгрөгөөр өссөн нь төмрийн баяжмалын борлуулалтын орлого 30.3 хувиар, төмрийн хүдрийн борлуулалтын орлого 36.4 хувиар нэмэгдсэн нь нөлөөлсөн.
- Авлага дансны үлдэгдэл 24,011.6 сая төгрөгөөр өссөн нь Xizhou shanghai technology компаниас 511.8 сая, Мөнхөд гэрэлтэх транс ХХК-аас авах 354.2 сая төгрөгийн борлуулалтын авлага, Улаанбаатар төмөр замд вагон захиалгын 325.6 сая төгрөгийн авлага нэмэгдсэн зэргээс шалтгаалсан байна. Авлага нэмэгдэхэд татварын авлагууд ихээхэн нөлөө үзүүлсэн байна. Тухайлбал: ААНОАТ-ийн авлага 11,695.0 сая, НӨАТ-ын авлага 1,743.8 сая, ХХОАТ-ын авлага 91.4 сая, АМНАТ-ийн авлага 5,432.5 сая төгрөгөөр тус тус нэмэгдэж татварын авлага 27,587.5 сая төгрөгийн үлдэгдэлтэй байгаа нь өмнөх оноос 27,101.4 сая төгрөг буюу 56.8 дахин нэмэгдсэн.
Татварын ерөнхий газраас тус байгууллагын 2017-2018 оны албан татвар ногдуулалт, төлөлтийн байдалд хийсэн хяналт шалгалтаар 10,140.9 сая төгрөгийн төлбөр ногдуулсан байна. Монголросцветмет ХХК-ийн (хуучин нэрээр) үйл ажиллагааны тухай Монгол Улсын Засгийн газар Оросын Холбооны Улсын Засгийн газар хоорондын 2007 оны 04 дүгээр сарын 25-ны өдрийн хэлэлцээр дуусгавар болоогүй гэж үзэн тус байгууллага татварын маргаан таслах зөвлөлд хандсанаар 263.4 сая төгрөгийн ногдуулалтыг хүчингүй болгуулан 9,877.5 сая төгрөгийн төлбөр хэвээр үлдсэн тул Захиргааны хэргийн шүүхэд гомдол гаргасан байна. Нийслэлийн татварын албанаас тус үйлдвэрийн газрын харилцах данснаас 7,974.7 сая төгрөг татан авсныг ААНОАТ-ын авлагаар бүртгэсэн нь авлагын өсөлтөд нөлөөлсөн байна.
- Урьдчилж гарсан зардал дансны үлдэгдэл 3,123.6 сая төгрөгөөр нэмэгдсэн дараах ажил гүйлгээний төлбөрийг урьдчилан шилжүүлсэнтэй холбоотой байна. Үүнд:
 - Майнс Ап ХХК-тай гэрээ байгуулан Liebherr R945 маркийн 3 ширхэг экскаваторыг “Шижир алт” алтны үйлдвэрт худалдан авахаар 1,350.0 сая төгрөг;
 - “ТОМРА Sorting Gmdh” компаниас Өргөний ордын 9 дүгээр хүдрийн бүсийн болон Зүүн цагаан дэлийн ордын жоншны хүдрийг лазер болон рентген туяа мэдрэгчтэй төхөөрөмжийн тусламжтайгаар хүдэр дэх кальци-карбонатын агуулгыг бууруулах ажлын хүрээнд байгуулсан гэрээний 1 дүгээр ээлжийн төлбөр 572.0 сая төгрөг,
 - Зүүн цагаан дэл цехийн уулын бэлтгэл ажил болон ажилчдын байр барих бүтээн байгуулалтын зардалд 1,448.2 сая төгрөг,

- Хэнтий аймгийн Бор-Өндөр сум дахь төвийн хатуу хучилттай автозамыг шинэчилж шинээр асфальт бетоноор хучих ажлыг гүйцэтгэж буй Батгурван Эрдэнэ ХХК-д гэрээний гүйцэтгэлийн дагуу 1,897.0 сая төгрөгийн санхүүжилтийг тус тус урьдчилан төлсөн.
- Бараа материалын дансны үлдэгдэл 21,395.2 сая төгрөгөөр өссөн нь Улаанбаатар төмөр зам хувь нийлүүлсэн нийгэмлэгтэй бүтээгдэхүүн экспортлох вагон хангалтын гэрээнд зааснаас 18 хувиар дутуу хангагдсан. Мөн 2021 оны сүүлээр ууттай баяжмалын экспортыг БНХАУ-ын Эрээн өртөө хүлээн авахгүй зэрэг шалтгаанаар 11 дүгээр сарын 2-ны өдрөөс хойш нойтон баяжмал ачих зөвшөөрөл олгоогүй тул ачилт хийгдээгүйгээс 19,517.5 сая төгрөгийн бэлэн бүтээгдэхүүний үлдэгдэлтэй байна.
- Үндсэн хөрөнгийн дансны үлдэгдэл 11,468.9 сая төгрөгөөр өссөн нь ТӨБЗГ-ын тогтоолоор 10,602.8 сая төгрөгийн үндсэн хөрөнгө худалдан авч, хөрөнгө оруулалтын төлөвлөгөөний дагуу Батс-өргөө ХХК-тай дахин төлөвлөлтийн орон сууцны суурин хэсгийг дуусаагүй барилга дансанд 9,351.0 сая төгрөгөөр хуримтлуулан бүртгэсэн. Элэгдлээрээ өртгөө нөхсөн 269.4 сая төгрөгийн хөрөнгө худалдан борлуулж 4,166.3 сая төгрөгийн хөрөнгө акталж данснаас хассан зэрэг нь нөлөөлжээ.
- Өр төлбөрийн данс өмнөх оноос 24,924.0 сая төгрөгөөр өссөн нь төмрийн баяжмал болон хүдэр “худалдах, худалдан авах гэрээн”-нд бүтээгдэхүүний төлбөрийг урьдчилан авахаар тусгасан мөн гэрээний нийт үнийн дүнгийн 5 хувьтай тэнцэх хэмжээний барьцаа төлбөр байршуулахаар заасны дагуу нийт 44,042.5 сая төгрөг урьдчилан авсан.

4.4.Техник, эдийн засгийн үзүүлэлт, зорилтот түвшний гүйцэтгэл

Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 3, 20 дугаар зүйлийн 20.1.3-д заасны дагуу гүйцэтгэх захирал нь байгууллагын үйлдвэрлэл, санхүүгийн төлөвлөгөө боловсруулж, зохих байгууллагаар батлуулж, биелэлтийг хангах үүрэгтэй.

ТӨБЗГ-ын 2020 оны 609 дүгээр тогтоолоор 2021 оны эдийн засгийн үндсэн үзүүлэлт, зорилтот түвшин, хөрөнгө оруулалтын төлөвлөгөөг баталж, 2021 оны 30 дугаар тогтоолоор тодотгосон байна. Тайлант оны нийт орлогыг 179,166.4 сая төгрөгөөр, нийт зардлыг 157,456.8 сая төгрөгөөр, цэвэр ашгийг 21,709.6 сая төгрөгөөр тогтоосон байна. Гүйцэтгэлээр 256,336.4 сая төгрөгийн орлого бүрдүүлж, 170,531.7 сая төгрөгийн зардал гарган 85,804.7 сая төгрөгийн ашигтай ажилласан байна.

Цэвэр ашгийн өсөлтөд нөлөөлсөн гол хүчин зүйл нь олон улсын зах зээл дэх уул уурхайн бүтээгдэхүүний үнийн өсөлт тэр дундаа төмрийн хүдрийн баяжмалын 1 тонны үнийг дунджаар 143.5 мянган төгрөгөөр төлөвлөсөн бол гүйцэтгэлээр 290.0 мянган төгрөг болж тонн тутамдаа 146.5 мянган төгрөгөөр өссөн нь борлуулалтын орлого, цэвэр ашиг нэмэгдэхэд голлох нөлөө үзүүлсэн байна.

Борлуулалтын орлого гүйцэтгэлээр 77,170.1 сая төгрөгөөр өссөн нь Fe-65 төмрийн нойтон баяжмал болон Fe-52 төмрийн хуурай баяжмалын экспортын тоо хэмжээний өсөлт орлогыг 97,650.6 сая төгрөгөөр нэмэгдүүлсэн бол хайлуур жоншны баяжмал, алт болон төмрийн хүдрийн борлуулалтын хэмжээ буурч борлуулалтын орлогыг 21,069.9 сая төгрөгөөр бууруулсан үзүүлэлттэй байна.

Хайлуур жоншны баяжмалын борлуулалт 84 хувийн гүйцэтгэлтэй байгаа нь цар тахлын хөл хорионы дэглэмээс шалтгаалан “Бор-Өндөр” уулын баяжуулах үйлдвэрийн жоншны хүдрийн далд уурхай 4 сар зогсож олборлолт явагдаагүйтэй холбоотой байна.

Үйлдвэрийн газрын алт олборлолтын үйл ажиллагаа нь Төв аймгийн Заамар сум болон Булган аймгийн Бүрэгхангай сумдын хилийн бүсийг дамнан уулын ажил явуулдаг бөгөөд хөл хорионы улмаас уурхайн зорчих хөдөлгөөн зогсож үйлдвэрлэлийн хэвийн үйл ажиллагаа алдагдаж олборлолтын төлөвлөгөө 42.4 хувиар тасарсан байна.

Байгууллага 149,759.5 сая төгрөгийн зардалтай ажиллахаар төлөвлөснөөс гүйцэтгэлээр 158,638.9 сая төгрөгийн зардал гаргаж 8,879.4 сая төгрөгөөр өссөн нь төмрийн баяжмалын экспортын хэмжээ нэмэгдэж үнэ өссөнөөр АМНАТ 10,161.4 сая төгрөгөөр, төмөр замын тээврийн зардал 1,205.7 сая төгрөгөөр тус тус нэмэгдсэн нь гол нөлөө үзүүлсэн байна.

Хөрөнгө оруулалтын 10 арга хэмжээнд 47,869.7 сая төгрөгийг төлөвлөж 23,132.1 сая төгрөг буюу 48 хувийн гүйцэтгэлтэй байна.

Эдийн засгийн үндсэн үзүүлэлт, зорилтот түвшний төлөвлөгөө, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.5-д харуулав.

5. Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайлангийн аудитын санал дүгнэлтээс тусад нь салгах ёстой гэж заасан байна.

5.1 Шилэн дансны мэдээлэл

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор www.shilendans.gov.mn цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Аудитаар тус хуулийн 6 дугаар зүйлд заасан мэдээллийн давхардал, ач холбогдол, үр нөлөөг харгалзан дараах 10 төрлийн мэдээллийг Шилэн дансны нэгдсэн цахим хуудаст ил тод байршуулсан эсэхийг хамруулан шалгалаа.

Шилэн дансны цахим хуудсанд нийт байршуулбал зохих 1,444,379.6 сая төгрөгийн 6202 мэдээллийг хугацаанд мэдээлсэн байна.

5.2 Бусад хууль тогтоомжийн хүрээнд

Нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийн түвшинд хэрэгжүүлсэн горим, сорилд үндэслэн шилэн дансанд байршуулсан мэдээлэл нь шилэн дансны тухай хууль тогтоомжийн холбогдох заалттай нийцэж байна гэж дүгнэлээ.

Засгийн газрын 2021 оны “Төсвийн хэмнэлтийн талаар авах арга хэмжээний тухай” 43 дугаар тогтоолын хэрэгжилтийг шалган үзэхэд дараах байдалтай байна.

1. Спортын уралдаан тэмцээн зохион байгуулахад зориулан 12.7 сая төгрөг зарцуулсан байна. Энэ нь Засгийн газрын 2021 оны “Төсвийн хэмнэлтийн талаар авах зарим арга хэмжээний тухай” 43 дугаар тогтоолын 1.6-д “Засгийн газрын шийдвэр гарснаас бусад баяр ёслол, тэмдэглэлт ой, урлагийн наадам, спортын уралдаан тэмцээн, салбарын

өдөр, аялал зугаалга зэргийг зохион байгуулахгүй байх... " гэж заасантай нийцэхгүй, санхүүгийн тайлангийн эрх ба үүрэг батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Засгийн газрын тогтоолыг мөрдөж ажиллах албан шаардлага хүргүүлэх.

Нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийн түвшинд хэрэгжүүлсэн горим, сорилд үндэслэн Засгийн газрын 2021 оны “Төсвийн хэмнэлтийн талаар авах арга хэмжээний тухай” 43 дугаар тогтоолын холбогдох заалтуудтай нийцээгүй байна гэж дүгнэлээ.

6. Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

Завсрын аудитаар 1,024.3 сая төгрөгийн алдаа, зөрчил илрүүлж, жилийн эцсийн санхүүгийн тайлангийн аудитын илрүүлэлтэд тусгасан.

Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар илэрсэн 1,486.5 сая төгрөгийн зөрчилд өгсөн 4 төлбөрийн актыг бүрэн хэрэгжүүлсэн, 2 зөвлөмж 50 хувь, 804.5 сая төгрөгийн зөрчлийг арилгах 6 албан шаардлага 96.4 хувийн биелэлттэй байна.

Хүснэгт 3. Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар өгсөн төлбөрийн акт, албан шаардлагын хэрэгжилт /мянган төг/

Үзүүлэлт	Өмнөх оны илрүүлэлт		Биелэлт		Зөрүү		
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Хувь
Төлбөрийн акт	4	682,017.5	4	682,017.5	0	-	100.0
Албан шаардлага	6	804,500.0	5	775,857.0	1	28,643.0	96.4
Зөвлөмж	2	-	1		1	-	50.0
Нийт дүн	12	1,486,517.5	10	1,457,874.5	2	28,643.0	98.1

Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар шаардлагагүй илүүдэл нөөц хөрөнгийн ашиглалтыг сайжруулан ажиллах талаар хүргүүлсэн албан шаардлага болон Нягтлан бодох бүртгэлийн санхүүгийн программ хангамжийг Интерактив Би Ай ХХК-тай хамтран ажиллаж стандарт, загварт нийцүүлэн сайжруулалт хийх зөвлөмж тус тус хэрэгжээгүй байна. Хэрэгжээгүй зөвлөмжид албан шаардлага хүргүүлэв.

7. Дараагийн аудитаар анхаарах асуудал

Цаг хугацааны хязгаарлагдмал байдлаас шалтгаалан хянаж амжаагүй анхаарал татсан дараах асуудлуудыг дараагийн аудитаар авч үзэхээр шийдвэрлэсэн. Үүнд:

- Урт хугацаат хөрөнгө оруулалт буюу тусгай зөвшөөрөл бүхий талбай дээр хийгдэж байгаа хайгуул үнэлгээний хөрөнгийн зардал,
- Монголросцветмет ТӨҮГ-ийн гадаад, дотоодын аж ахуйн нэгжүүдтэй байгуулсан “Ашигт малтмалын хүдэр болон баяжмалыг борлуулах гэрээ”-ны биелэлт,
- Ашигт малтмалын тусгай зөвшөөрөлтэй ордод бүтээгдэхүүн хуваах зарчмаар хамтран ажиллаж буй компаниудын ажлын гүйцэтгэл,

8. Аудитын илрүүлэлт

Аудитаар нийт 1,201.2 сая төгрөгийн алдаа зөрчил илэрснээс, 387.0 сая төгрөгийн зөрчилд төлбөрийн акт тогтоож, 814.2 сая төгрөгийн зөрчилд албан шаардлага хүргүүлсэн.

Залруулагдаагүй 1,201.2 сая төгрөгийн алдаа зөрчил нь тогтоосон 2,357.7 сая төгрөгийн ерөнхий материаллаг байдлын түвшнээс 1,156.5 сая төгрөгөөр бага байгаа тул “Зөрчилгүй” дүгнэлт өглөө.

8.1 Төлбөрийн акт

1. Ажиллагсдад 214.2 сая төгрөгийн урамшуулал илүү тооцоолон олгосон байна .

Энэ нь Төсвийн тухай хуулийн 3 дугаар зүйлийн 3.1-т "Энэ хууль нь төсвийн байгууллага, түүний албан тушаалтан, Засгийн газрын болон орон нутгийн тусгай сан, төрийн чиг үүрэгт хамаарах ажил, үйлчилгээг гэрээний үндсэн дээр хэрэгжүүлдэг болон хууль тогтоомжийн дагуу төсөвт орлого төвлөрүүлэх үүрэг хүлээдэг төрийн болон орон нутгийн өмчит, төрийн болон орон нутгийн өмчийн оролцоотой хуулийн этгээдэд хамаарна", 5 дугаар зүйлийн 5.1.3-т "санхүү, төсвийн зохистой удирдлагыг хэрэгжүүлэх", мөн хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1. "төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах" заалттай нийцэхгүй, санхүүгийн тайлангийн эрх ба үүрэг, нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Төсөвт төвлөрүүлэх төлбөрийн акт тогтоох.

2. Тайлант онд ажиллагсдад 148.3 сая төгрөгийн шагнал давхардуулан олгосон байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1-д "*төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах*", Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.4-д "Үнэн зөв байх", гэсэн заалттай нийцэхгүй, санхүүгийн тайлангийн эрх ба үүрэг, нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Төсөвт төвлөрүүлэх төлбөрийн акт тогтоох.

3. Дорноговь аймгийн Их хэт сумын нутагт орших Хамар усны хайлуур жоншны ордын ил уурхайн барилга байгууламжийг холбогдох эрх бүхий байгууллагын зөвшөөрөлгүй Баянтэгш Импекс ХХК-тай "Хамтран ажиллах гэрээ"-г байгуулан ашиглуулсан бөгөөд 24.5 сая төгрөгийн түрээсийн төлбөр төвлөрүүлээгүй байна.

Энэ нь Засгийн газрын 2001 оны 134 дүгээр тогтоолоор баталсан "Төрийн өөрийн өмчийн эд хөрөнгө түрээслүүлэх журам"-ын 9-д "Төрийн өөрийн өмчийн эд хөрөнгийг түрээслэгч нь түрээсээр эзэмшиж буй төрийн өөрийн өмчийн эд хөрөнгийг дамжуулан түрээслүүлэх, хамтран түрээслэх, эрх залгамжлан түрээслэх бол Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын зөвшөөрөл авна" гэж заасныг мөрдөөгүй, санхүүгийн тайлангийн эрх ба үүрэг батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Төсөвт төвлөрүүлэх төлбөрийн акт тогтоох.

8.2 АЛБАН ШААРДЛАГА

1. Бор-Өндөр УБУ-ийн удирдлага нэр бүхий 57 ажилтанд 2021 оны 1-6 саруудад гэрээ шинэчлэн байгуулалгүй 154.6 сая төгрөгийн захирлын дотоод гэрээний нэмэгдэл олгосон байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 3 дугаар зүйлийн 3.1-т "Энэ хууль нь төсвийн байгууллага, түүний албан тушаалтан, Засгийн газрын болон орон нутгийн тусгай сан, төрийн чиг үүрэгт хамаарах ажил, үйлчилгээг гэрээний үндсэн дээр хэрэгжүүлдэг болон хууль тогтоомжийн дагуу төсөвт орлого төвлөрүүлэх үүрэг хүлээдэг төрийн болон орон

нутгийн өмчит, төрийн болон орон нутгийн өмчийн оролцоотой хуулийн этгээдэд хамаарна", 5 дугаар зүйлийн 5.1.3-т "санхүү, төсвийн зохистой удирдлагыг хэрэгжүүлэх" гэсэн заалттай нийцэхгүй, санхүүгийн тайлангийн эрх ба үүрэг, иж бүрэн байх батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Холбогдох хууль тогтоомж, цалин хөлсний журмыг мөрдөж ажиллах албан шаардлага хүргүүлэх.

2. Монголросцветмет ТӨҮГ-ын захирал ТӨБЗГ-ын хооронд байгуулсан контракт гэрээний ажил олгогчийн эрх үүрэг хэсэгт "мэргэжил, мэргэжлийн өндөр чадвар, хөдөлмөрийн бүтээмж, ажлын үр дүнд тохирсон нэмэгдэл олгох" гэж заасны дагуу зарим ажилчидтай гэрээ байгуулан нэмэгдэл олгохдоо мэргэжлийн өндөр ур чадвар, нарийн мэргэжлийн ажилчдын жагсаалтыг үндэслээгүй байна.

Энэ нь захирлын 2019 оны А/545 дугаар тушаалаар батлагдсан "Цалин хөлсний тухай журам"-ын 3.3.7-д "... Үйлдвэрийн газрын захиралтай Нэмэгдлийн гэрээ байгуулсан ажилтны нэмэгдэл цалинг үйлдвэрийн газарт ур чадвар, нарийн мэргэшил, мэргэжил шаардсан ажлын байранд мэргэжилтэнд нэмэгдэл цалин олгох", Монголросцветмет ТӨҮГ-ын захирлын ТӨБЗГ-тай байгуулсан контракт гэрээний 9-д "Ажил олгогчийн эрх үүрэг" хэсэгт заасныг тус тус мөрдөөгүй, санхүүгийн тайлангийн эрх ба үүрэг, иж бүрэн байх батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Цалин хөлсний журмыг мөрдөж ажиллах албан шаардлага хүргүүлэх.

3. Бор Өндөр УБҮ-ийн бараа, материалын дансанд 2006-2018 онуудад худалдан авсан 2019 оноос хойш хөдөлгөөн хийгээгүй 618.6 сая төгрөгийн материал, сэлбэг хэрэгслийн үлдэгдэлтэй, бараа материалын дансанд түүвэр тооллого хийхэд тэнцүү талт булан төмрийн нөөц байхад нэмж 12.4 сая төгрөгийн худалдан авалт хийсэн байна.

Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 18 дугаар зүйлийн 18.1-д "Нягтлан бодох бүртгэлийг удирдан зохион байгуулах үүргийг аж ахуйн нэгж байгууллагын удирдлага хүлээнэ", 20.2.6-д "эд хөрөнгийн болон төлбөр тооцооны тооллого хийх, үр дүнг шийдвэрлэх, бэлтгэн нийлүүлэгч, худалдан авагчтай тооцоо хийж, үлдэгдлийг баталгаажуулж, баримтжуулах ажлыг зохион байгуулах, удирдах" гэж заасантай нийцэхгүй, санхүүгийн тайлангийн эрх ба үүрэг, иж бүрэн байх батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Бараа материалын нөөцийг зохистой хэмжээгээр бүрдүүлхэд анхаарч ажиллах албан шаардлага хүргүүлэх.

4. Нягтлан бодох бүртгэлд Интер Актив Би Ай ХХК-ийн Даймонд программ хангамжаас ерөнхий журнал харилцагчийн нэр, харьцсан данс гардаггүй дутагдалтай талууд байгааг арилгах талаар өмнөх аудитаар өгсөн зөвлөмж хэрэгжүүлээгүй байна.

Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 18 дугаар зүйлийн 18.1 "Нягтлан бодох бүртгэлийг удирдан зохион байгуулах үүргийг аж ахуйн нэгж, байгууллагын гүйцэтгэх удирдлага хүлээнэ", Сангийн сайдын 2014 оны 249 тоот Нягтлан бодох бүртгэлийн дансны жишиг жагсаалт, Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.3 "Шалгагдагч этгээд болон холбогдох бусад албан тушаалтан нь энэ хуулийн 20.2-т заасан зөвлөмжийн хүрээнд хэрэгжүүлсэн ажил, түүний үр дүнг төрийн аудитын байгууллагаас тогтоосон хугацаанд мэдэгдэнэ" гэж заасантай нийцэхгүй, санхүүгийн тайлангийн ангилал болон ойлгомжтой байх батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Санхүүгийн программ хангамжийг стандарт, загварт нийцүүлэн сайжруулалт хийх албан шаардлага хүргүүлэх.

5.Борлуулалтын гэрээ байгуулан ажиллаж буй нэр бүхий 10 байгууллагын 2013-2021 онуудад үүссэн 1,042.0 сая төгрөгийн авлагыг барагдуулаагүй шүүхэд шилжүүлсэн, 28.6 сая төгрөгийн авлага, өглөгийг тооцоо нийлж актаар баталгаажуулаагүй байна.

Энэ нь Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 71 дугаар зүйлийн 71.8 “өр, авлагыг барагдуулах арга хэмжээ авч үлдэгдлийг тооцсон байх”, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2.5 “дансны өглөг, авлага ба төлбөрийн тооцоог хянах, ажил, гүйлгээг гарахаас нь өмнө хянан, баталгаажуулах”, 20.2.6 “эд хөрөнгийн болон төлбөр тооцооны тооллого хийх, үр дүнг шийдвэрлэх, бэлтгэн нийлүүлэгч, худалдан авагчтай тооцоо хийж, үлдэгдлийг баталгаажуулж, баримтжуулах ажлыг зохион байгуулах, удирдах” гэж заасантай нийцэхгүй, санхүүгийн тайлангийн эрх ба үүрэг батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Авлага, өглөгийн үлдэгдлийг тооцоо нийлж актаар баталгаажуулж, он удаан жил болсон авлагыг барагдуулах арга хэмжээ авах албан шаардлага хүргүүлэх.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

9. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн нэгтгэл

/мянган төгрөгөөр/

д/д	Байгууллагын нэр	Аудитын код	Алдаа зөрчлийн утга	Тогтоосон акт, албан шаардлага өгсөн зөвлөмжийн утга	Нийт алдаа, зөрчлийн дүн		ҮҮНЭЭС			
					тоо	Дүн	Акт		Албан шаардлага	
							тоо	Дүн	тоо	дүн
Санхүүгийн тайлангийн аудитын асуудлаар										
1	Монголросцветмет ТӨҮГ	АХГ-2022/54/НА-СТА-ТӨА	Ажиллагсад 214,200,000 төгрөгийн урамшуулал илүү тооцоолон олгосон,	Илүү тооцоолон олгосон урамшууллыг улсын төсөвт төвлөрүүлэх	1	214,200.0	1	214,200.0		
2	Монголросцветмет ТӨҮГ	АХГ-2022/54/НА-СТА-ТӨА	Тайлант онд ажиллагсад 148,340,260.00 төгрөгийн шагнал, урамшуулал давхардуулан олгосон,	Давхардуулан олгосон шагнал, урамшууллыг улсын төсөвт төвлөрүүлэх	1	148,340.3	1	148,340.3		
3	Монголросцветмет ТӨҮГ	АХГ-2022/54/НА-СТА-ТӨА	Дорноговь аймгийн Их хэт сумын нутагт орших Хамар усны хайлуур жоншны ордын ил уурхайн барилга байгууламжийг холбогдох эрх бүхий байгууллагын зөвшөөрөлгүй Баянтэгш Импекс ХХК-тай "Хамтран ажиллах гэрээ"-г байгуулан ашиглуулж байна,	Гэрээний дагуу төлбөл зохих түрээсийн төлбөрийг улсын төсөвт төвлөрүүлэх	1	24,500.0	1	24,500.0		
4	Монголросцветмет ТӨҮГ	АХГ-2022/54/НА-СТА-ТӨА	Бор-Өндөр УБҮ-ийн удирдлага нь нэр бүхий 57 ажилтанд 2021 оны 1-6 саруудад гэрээ шинэчлэн байгуулалгүй 154,600,300 төгрөгийн дотоод гэрээний нэмэгдэл олгосон,	Холбогдох хууль тогтоомж, цалин хөлсний журмыг мөрдөж ажиллах	1	154,600.3			1	154,600.3
5	Монголросцветмет ТӨҮГ	АХГ-2022/54/НА-СТА-ТӨА	Монголросцветмет ТӨҮГ-ын захирал ТӨБЗГ-ын хооронд байгуулсан контракт гэрээний ажил олгогчийн эрх үүрэг хэсэгт "мэргэжил, мэргэжлийн өндөр чадвар, хөдөлмөрийн бүтээмж, ажлын үр дүнд тохирсон нэмэгдэл олгох" гэж заасны дагуу зарим ажилчидтай гэрээ байгуулан нэмэгдэл олгохдоо мэргэжлийн өндөр ур чадвар, нарийн мэргэжлийн ажилчдын жагсаалтыг үндэслээгүй,	Цалин хөлсний журмыг мөрдөж ажиллах	1	-			1	
6	Монголросцветмет ТӨҮГ	АХГ-2022/54/НА-СТА-ТӨА	- Бор Өндөр УБҮ-ийн бараа материалын дансанд 2006-2018 онуудад худалдан авсан 2019 оноос хойш хөдөлгөөн хийгдээгүй 618,601,100 төгрөгийн материал, сэлбэг хэрэгслийн үлдэгдэлтэй, - Бараа материалын дансанд түүвэр тооллого хийхэд тэнцүү талт булан төмрийн нөөц байхад нэмж 12,370,303 төгрөгийн худалдан авалт хийсэн,	Бараа материалын нөөцийг зохистой хэмжээгээр бүрдүүлэх	1	630,971.4			1	630,971.4

Монголросцветмет ТӨҮГ-ын 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд
хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан

7	Монголросцветмет ТӨҮГ	АХГ- 2022/54/НА- СТА-ТӨА	Борлуулалтын гэрээ байгуулан ажиллаж буй нэр бүхий 10 байгууллагын 2013-2021 онуудад үүссэн 1,042,008,229 төгрөгийн авлагыг барагдуулаагүй шүүхэд шилжүүлсэн., 28,642,987 төгрөгийн авлага, өглөг тооцоо нийлж актаар баталгаажуулаагүй,	Авлага өглөгийн үлдэгдлийг тооцоо нийлж актаар баталгаажуулж, он удаан жил болсон авлагыг барагдуулах арга хэмжээ авах	1	28,643.0			1	28,643.0
8	Монголросцветмет ТӨҮГ	АХГ- 2022/54/НА- СТА-ТӨА	Нягтлан бодох бүртгэлд "Интер Актив Би Ай" ХХК-ийн даймонд программыг ашигладаг бөгөөд тус программ хангамжаас ерөнхий журнал харилцагчийн нэр, харьцсан данс гардаггүй дутагдалтай талууд байгаа талаар өмнөх аудитаар зөвлөмж өгсөн боловч хэрэгжүүлээгүй,	Санхүүгийн программ хангамжийг стандарт, загварт нийцүүлэн сайжруулалт хийх	1	-			1	
Дүн					8	1,201,255.0	3	387,040.3	5	814,214.7
Санхүүгийн тайлангийн асуудлаар шалгасан нийцлийн асуудал										
9	Монголросцветмет ТӨҮГ	АХГ- 2022/54/НА- СТА-ТӨА	Спортын уралдаан тэмцээн зохион байгуулан 12,716,000 төгрөг зарцуулсан.	Засгийн газрын тогтоолыг мөрдөж ажиллах	1	12,716.0			1	12,716.0
Дүн					1	12,716.0			1	12,716.0
Дүн					9	1,213,971.0	3	387,040.3	6	826,930.7



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР
АКТ

2022 оны 03 дугаар сарын 15 № 108/А0140068

Улаанбаатар хот

АКТ - 2022/54/НА-СМА-МАА
Төлбөр барагдуулах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.8-д заасны дагуу Монголросцветмет ТӨҮГ-ын 2021 оны санхүүгийн тайлан, зорилтот түвшинд хийсэн аудитаар дараах зөрчлүүд илэрлээ. Үүнд:

1. Дорноговь аймгийн Их хэт сумын нутагт орших Хамар усны хайлуур жоншны ордын нл уурхайн барилга байгууламжийг холбогдох эрх бүхий байгууллагын зөвшөөрөлгүй Баянтэгш Импекс ХХК-тай "Хамтран ажиллах гэрээ"-г байгуулан ашиглуулсан бөгөөд 24,500,00.00 төгрөгийн түрээсийн төлбөр төвлөрүүлээгүй байна.


Энэ нь Засгийн газрын 2001 оны 134 дүгээр тогтоолоор баталсан "Төрийн өөрийн өмчийн эд хөрөнгө түрээслүүлэх журам"-ын 9-д "Төрийн өөрийн өмчийн эд хөрөнгийг түрээслэгч нь түрээсээр эзэмшиж буй төрийн өөрийн өмчийн эд хөрөнгийг дамжуулан түрээслүүлэх, хамтран түрээслэх, эрх залгамжлан түрээслэх бол Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын зөвшөөрөл авна" гэж заасантай нийцэхгүй байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.2 "Шалгагдагч этгээд төсөв, санхүү, нягтлан бодох бүртгэлийн үйл ажиллагаа болон төсвийн орлого бүрдүүлэх, зарцуулах, нийтийн өмч, хөрөнгө олж бэлтгэх, ашиглах, зарцуулах, хадгалах, хамгаалахтай холбоотой хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн бол төлбөрийн акт тогтооно", Монгол Улсын Ерөнхий Аудиторын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан "Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох" журмын 4.2.3-д заасныг үндэслэн **ТОГТООХ** нь:

1. Гэрээний дагуу төлбөл зохих түрээсийн төлбөр 24 500,000.00 төгрөгийг Үндэсний аудитын газрын Төрийн сан банканд дахь Аудитын шалгалтын орлого 100900000601 тоот дансанд төвлөрүүлэх;
2. Актын биелэлтийг 2022 оны 9 дүгээр сарын 30-ны дотор Үндэсний аудитын газарт ирүүлэхийг Монголросцветмет ТӨҮГ-ын захирал Б.Мөнхбат, ерөнхий нягтлан бодогч Б.Цэнд-Аюуш нарт хариуцуулав.

АКТ ТОГТООСОН:

АУДИТЫН ХОЁРДУГААР ГАЗРЫН
ЗАХИРАЛ, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР
АУДИТЫН МЕНЕЖЕР
АУДИТОР
АУДИТОР



Ц.НАРАНЧИМЭГ
Д.ЭНХДАЛАЙ
М.ЛХАГВАСҮРЭН
О.БАЯРМАА



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР
АКТ

2022 оны 03 дугаар сарын 15

№ 109/АД/40066

Улаанбаатар хот

АКТ - 2022/54/МА - СТА - ТӨА
Төлбөр барагдуулах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.8-д заасны дагуу Монголросцветмет ТӨҮГ-ын 2021 оны санхүүгийн тайлан, зорилтот түвшинд хийсэн аудитаар дараах зөрчлүүд илэрлээ. Үүнд:

1. Ажиллагсад 214,200,000.00 төгрөгийн урамшууллыг илүү олгож, 148,340,260.00 төгрөгийн шагналыг давхардуулан олгосон байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 3 дугаар зүйлийн 3.1 "Энэ хууль нь төсвийн байгууллага, түүний албан тушаалтан, Засгийн газрын болон орон нутгийн тусгай сан, төрийн чиг үүрэгт хамаарах ажил, үйлчилгээг гэрээний үндсэн дээр хэрэгжүүлдэг болон хууль тогтоомжийн дагуу төсөвт орлого төвлөрүүлэх үүрэг хүлээдэг төрийн болон орон нутгийн өмчит, төрийн болон орон нутгийн өмчийн оролцоотой хуулийн этгээдэд хамаарна", 6 дугаар зүйлийн 6.4.1 "төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах" Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.4 "Үнэн зөв байх", 19 дүгээр зүйлийн 19.1 "Аж ахуйн нэгж, байгууллагын нягтлан бодох бүртгэлийн дотоод хяналтын бодлого, удирдлага, зохион байгуулалтыг аж ахуйн нэгж, байгууллагын эрх бүхий этгээд тодорхойлно" заалтуудтай тус тус нийцэхгүй байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.2 "Шалгаадагч этгээд төсөв, санхүү, нягтлан бодох бүртгэлийн үйл ажиллагаа болон төсвийн орлого бүрдүүлэх, зарцуулах, нийтийн өмч, хөрөнгө олж бэлтгэх, ашиглах, зарцуулах, хадгалах, хамгаалахтай холбоотой хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн бол төлбөрийн акт тогтооно", Монгол Улсын Ерөнхий Аудиторын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан "Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох" журмын 4.2.3.-д заасныг үндэслэн **ТОГТООХ нь:**

1. Ажиллагсад илүү тооцоолон олгосон урамшуулал болон давхардуулан олгосон шагнал нийт 362,540,260.00 төгрөгийг Үндэсний аудитын газрын Төрийн сан банкна дахь Аудитын шалгалтын орлого 100900000601 тоот дансанд төвлөрүүлэх;
2. Актын биелэлтийг 2022 оны 9 дүгээр сарын 30-ны дотор Үндэсний аудитын газарт ирүүлэхийг Монголросцветмет ТӨҮГ-ын захирал Б.Мөнхбат, ерөнхий нягтлан бодогч Б.Цэнд-Аюуш нарт хариуцуулав.

АКТ ТОГТООСОН:

АУДИТЫН ХОЁРДУГААР ГАЗРЫН
ЗАХИРАЛ, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР
АУДИТЫН МЕНЕЖЕР
АУДИТОР
АУДИТОР

Ц.НАРАНЧИМЭГ
Д.ЭНХДАЛАЙ
М.ЛХАГВАСҮРЭН
О.БАЯРМАА



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР
АЛБАН ШААРДЛАГА

2022 оны 03 дугаар сарын 15

№ 467/АОНСО68

Улаанбаатар хот

АХТ-2022/54/МА-СТА-ТВА.

Зөрчил арилгах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.8 заасны дагуу Монголросцветмет ТӨҮГ-ын 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

1. Нягтлан бодох бүртгэлд Интер Актив Би Ай ХХК-ийн Даймонд программ хангамжаас ерөнхий журнал харилцагчийн нэр, харьцсан данс гардаггүй дутагдалтай талууд байгааг арилгах талаар өмнөх аудитаар өгсөн зөвлөмж хэрэгжүүлээгүй байна.

Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 18 дугаар зүйлийн 18.1 "Нягтлан бодох бүртгэлийг удирдан зохион байгуулах үүргийг аж ахуйн нэгж, байгууллагын гүйцэтгэх удирдлага хүлээнэ", Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.3 "Шалгагдагч этгээд болон холбогдох бусад албан тушаалтан нь энэ хуулийн 20.2-т заасан зөвлөмжийн хүрээнд хэрэгжүүлсэн ажил, түүний үр дүнг төрийн аудитын байгууллагаас тогтоосон хугацаанд мэдэгдэнэ", Сангийн сайдын 2014 оны 249 дүгээр тушаалаар баталсан Нягтлан бодох бүртгэлийн дансны жишиг жагсаалттай тус тус нийцэхгүй байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1 "Шалгагдагч этгээд хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний боловч оусад эрх зүйн акт зөрчсөн, хуулиар хүлээсэн албан үүргээ биелүүлээгүй бол алдаа, зөрчлийг таслан зогсоох, давтан гаргуулахгүй байх талаар байгууллага, албан тушаалтанд албан шаардлага өгнө", Монгол Улсын Ерөнхий Аудиторын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох журмын 4.2.1-т заасныг үндэслэн **ШААРДАХ нь:**

1. Санхүүгийн программ хангамжийг стандарт, загварт нийцүүлэн сайжруулалт хийж, зөрчлийг арилган, албан шаардлагын биелэлтийг 2022 оны 9 дүгээр сарын 30-ны өдрийн дотор Үндэсний аудитын газарт ирүүлэх;
2. Цаашид алдаа, зөрчлийг давтан гаргахгүй байх, хууль тогтоомжийг хэрэгжүүлж ажиллахыг Монголросцветмет ТӨҮГ-ын захирал Б.Мөнхбат, ерөнхий нягтлан бодогч Б.Цэнд-Аюуш тарт даалгав.

АЛБАН ШААРДЛАГА ӨГСӨН

АУДИТЫН ХӨӨРДУГААР ГАЗРЫН
ЗАХИРАЛ ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР
АУДИТЫН МЕНЕЖЕР
АУДИТОР
АУДИТОР

Ц.НАРАНЧИМЭГ
Д.ЭНХДАЛАЙ
М.ЛХАГВАСҮРЭН
О.БАЯРМАА

Монгол Улс, Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг, 4-р хороо, Бага тойруу 3, Засгийн газрын 4 дүгээр байр, Утас 51-204230

9006109
9019120596

10.10.2020\Bichig\Bichig\Alban Shaardloga\2022\0315 Audiin 2 Gazar-146.Docx

0001081286



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР
АЛБАН ШААРДЛАГА

2022 оны 03 дугаар сарын 15

№ 462/А0140066

Улаанбаатар хот

АТТ - 2022/54/НАД-СТД-ТӨА
Зөрчил арилгах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.8 заасны дагуу Монголросцветмет ТӨҮГ-ын 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

1. Бор-Өндөр УБҮ-ийн бараа, материалын дансанд 2006-2018 онуудад худалдан авсан 2019 оноос хойш хөдөлгөөн хийгээгүй 618,601,100 төгрөгийн материал, сэлбэг хэрэгслийн үлдэгдэлтэй, бараа материалын дансанд түүвэр тооллого хийхэд тэнцүү талт булан төмрийн нөөц байхад нэмж 12,370,303.00 төгрөгийн худалдан авалт хийсэн байна.

Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 18 дугаар зүйлийн 18.1 "Нягтлан бодох бүртгэлийг удирдан зохион байгуулах үүргийг аж ахуйн нэгж, байгууллагын удирдлага хүлээнэ", 20 дугаар зүйлийн 20.2.6 "эд хөрөнгийн болон төлбөр тооцооны тооллого хийх, үр дүнг шийдвэрлэх, бэлтгэн нийлүүлэгч, худалдан авагчтай тооцоо хийж, үлдэгдлийг баталгаажуулж, баримтжуулах ажлыг зохион байгуулах, удирдах" гэж заасныг хэрэгжүүлээгүй байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1 "Шалгагдагч этгээд хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн, хуулиар хүлээсэн албан үүргээ биелүүлээгүй бол алдаа зөрчлийг таслан зогсоох, давтан гаргуулахгүй байх талаар байгууллага, албан тушаалтанд албан шаардлага өгнө", Монгол Улсын Ерөнхий Аудиторын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох журмын 4.2.1-т заасныг үндэслэн **ШААРДАХ нь:**

1. Бараа материалын нөөцийг зохистой хэмжээгээр бүрдүүлэх, зөрчлийг арилган, албан шаардлагын биелэлтийг 2022 оны 9 дүгээр сарын 30-ны өдрийн дотор Үндэсний аудитын газарт ирүүлэх;
2. Цаашид алдаа, зөрчлийг давтан гаргахгүй байх, хууль тогтоомжийг хэрэгжүүлж ажиллахыг Монголросцветмет ТӨҮГ-ын захирал Б.Мөнхбат, ерөнхий нягтлан бодогч Б.Цэнд-Аюуш нарт даалгав.

АЛБАН ШААРДЛАГА ӨГСӨН:

АУДИТЫН ХОЁРДУГААР ГАЗРЫН
ЗАХИРАЛ, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР
АУДИТЫН МЕНЕЖЕР
АУДИТОР
АУДИТОР

Ц.НАРАНЧИМЭГ
Д.ЭНХДАЛАЙ
М.ЛХАГВАСҮРЭН
О.БАЯРМАА

Монгол Улс, Улаанбаатар хот, Чингэлтэн дүүрэг, 1-р хороо, Бага тойрог-3, Засгийн газрын 4 дүгээр байр, Утас 51-264230

\\10.10.10.20\Bichig_Kherag\Alban_Shaardlaga\2022\0315_Auditin_2_Gazar-145.Docx

0001081284



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР
АЛБАН ШААРДЛАГА

2022 оны 03 дугаар сарын 15

№ 469/20140060

Улаанбаатар хот

АХТ-2022/54/МА-СТА-ТӨА
Зөрчил арилгах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.8 заасны дагуу Монголросцветмет ТӨҮГ-ын 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

1. Борлуулалтын гэрээ байгуулан ажиллаж буй нэр бүхий 10 байгууллагын 2013-2021 онуудад үүссэн 1,042,008,229.00 төгрөгийн авлагыг барагдуулаагүй шүүхэд шилжүүлсэн, 28,642.987.00 төгрөгийн авлага, өглөгийг тооцоо нийлж актаар баталгаажуулаагүй байна.

Энэ нь Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 71 дүгээр зүйлийн 71.8 "өр, авлагыг барагдуулах арга хэмжээ авч үлдэгдлийг тооцсон байх", Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2.5 "дансны өглөг, авлага ба төлбөрийн тооцоог хянах, ажил, гүйлгээг гарахаас нь өмнө хянан, баталгаажуулах", 20.2.6 "эд хөрөнгийн болон төлбөр тооцооны тооллого хийх, үр дүнг шийдвэрлэх, бэлтгэн нийлүүлэгч, худалдан авагчтай тооцоо хийж, үлдэгдлийг баталгаажуулж, баримтжуулах ажлыг зохион байгуулах, удирдах" гэж заасантай нийцэхгүй байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1 "Шалгагдагч этгээд хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн, хуулиар хүлээсэн албан үүргээ биелүүлээгүй бол алдаа, зөрчлийг таслан зогсоох, давтан гаргуулахгүй байх талаар байгууллага, албан тушаалтанд албан шаардлага өгнө", Монгол Улсын Ерөнхий Аудиторын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох журмын 4.2.1-т заасныг үндэслэн **ШААРДАХ нь:**

1. Авлага, өглөгийн үлдэгдлийг тооцоо нийлж, актаар баталгаажуулах, он удаан жил болсон авлагыг барагдуулах арга хэмжээ авч ажиллах, зөрчлийг арилган, албан шаардлагын биелэлтийг 2022 оны 9 дүгээр сарын 30-ны өдрийн дотор Үндэсний аудитын газарт ирүүлэх;
2. Цаашид алдаа, зөрчлийг давтан гаргахгүй байх, хууль тогтоомжийг хэрэгжүүлж ажиллахыг Монголросцветмет ТӨҮГ-ын захирал Б.Мөнхбат, ерөнхий нягтлан бодогч Б.Цэнд-Аюуш нарт даалгав.

АЛБАН ШААРДЛАГА ӨГСӨН:

АУДИТЫН ХОЁРДУГААР ГАЗРЫН
ЗАХИРАЛ ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР
АУДИТЫН МЕНЕЖЕР
АУДИТОР
АУДИТОР

Ц.НАРАНЧИМЭГ
Д.ЭНХДАЛАЙ
М.ЛХАГВАСҮРЭН
О.БАЯРМАА

Монгол Улс, Улаанбаатар хот, Сүхбаатар дүүрэг, 1-р хороо, Бага тойруу-8, Засгийн газрын 4 дүгээр байр, Утас 51-204230

990191203196

\\10.10.10.20\reg\reg\Alban_Shaardlaga\2022\0315_Auditin_2_Gazar-144.Docx

0001081282



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР
АЛБАН ШААРДЛАГА

2022 оны 03 дугаар сарын 15

№ 440/АД/40066

Улаанбаатар хот

АХТ-2022/54/НА-СТА-ТӨА
Зөрчил арилгах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.8 заасны дагуу Монголросцветмет ТӨҮГ-ын 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

Монголросцветмет ТӨҮГ нь спортын уралдаан тэмцээн зохион байгуулахад зориулан 12,716,000.00 төгрөг зарцуулсан байна.

Энэ нь Засгийн газрын 2021 оны "Төсвийн хэмнэлтийн талаар авах зарим арга хэмжээний тухай" 43 дугаар тогтоолын 1.6 "Засгийн газрын шийдвэр гарснаас бусад баяр ёслол, тэмдэглэлт ой, урлагийн наадам, спортын уралдаан тэмцээн, балбарын өдөр, аялал зугаалга зэргийг зохион байгуулахгүй байх..." гэж заасантай нийцэхгүй байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1 "Шалгагдагч этгээд хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн, хуулиар хүлээсэн албан үүргээ биелүүлээгүй бол алдаа, зөрчлийг таслан зогсоох, давтан гаргуулахгүй байх талаар байгууллага, албан тушаалтанд албан шаардлага өгнө", Монгол Улсын Ерөнхий Аудиторын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох журмын 4.2.1-т заасныг үндэслэн **ШААРДАХ нь:**

1. Засгийн газрын тогтоол, шийдвэрийг мөрдөн ажиллаж, зөрчлийг арилган, албан шаардлагын биелэлтийг 2022 оны 9 дүгээр сарын 30-ны өдрийн дотор Үндэсний аудитын газарт ирүүлэх;
2. Цаашид алдаа, зөрчлийг давтан гаргахгүй байх, хууль тогтоомжийг хэрэгжүүлж ажиллахыг Монголросцветмет ТӨҮГ-ын захирал Б.Мөнхбат, ерөнхий нягтлан бодогч Б.Цэнд-Аюуш нарт даалгав.

АЛБАН ШААРДЛАГА ӨГСӨН:

АУДИТЫН ХОЁРДУГААР ГАЗРЫН
ЗАХИРАЛ, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР
АУДИТЫН МЕНЕЖЕР
АУДИТОР
АУДИТОР

Ц НАРАНЧИМЭГ
Д ЭНХДАЛАЙ
М ЛХАГВАСҮРЭН
О БАЯРМАА





ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР
АЛБАН ШААРДЛАГА

2022 оны 03 дугаар сарын 15 № 441 /А0140066

Улаанбаатар хот

ААТ-2022/54/МӨ-СТО-ТӨӨ

Зөрчил арилгах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.8 заасны дагуу Монголросцветмет ТӨҮГ-ын 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

1. Бор-Өндөр УБҮ-ийн удирдлага нь нэр бүхий 57 ажилтанд 2021 оны 1-6 саруудад гэрээ шинэчлэн байгуулалгүй 154,600,300.00 төгрөгийн захирлын дотоод гэрээний нэмэгдэл олгосон,
2. Монголросцветмет ТӨҮГ-ын захирал ТӨБЗГ-ын хооронд байгуулсан контракт гэрээний ажил олгогчийн эрх, үүрэг хэсэгт "мэргэжил, мэргэжлийн өндөр чадвар, хөдөлмөрийн бүтээмж, ажлын үр дүнд тохирсон нэмэгдэл олгох" гэж заасны дагуу зарим ажилчидтай гэрээ байгуулан нэмэгдэл олгохдоо мэргэжлийн өндөр ур чадвар, нарийн мэргэжлийн ажилчдын жагсаалтыг үндэслээгүй байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 3 дугаар зүйлийн 3.1 "Энэ хууль нь төсвийн байгууллага, түүний албан тушаалтан, Засгийн газрын болон орон нутгийн тусгай сан, төрийн чиг үүрэгт хамаарах ажил, үйлчилгээг гэрээний үндсэн дээр хэрэгжүүлдэг болон хууль тогтоомжийн дагуу төсөвт орлого төвлөрүүлэх үүрэг хүлээдэг төрийн болон орон нутгийн өмчийн өмчийн оролцоотой хуулийн этгээдэд хамаарна", Захирлын 2019 оны А/545 дугаар тушаалаар батлагдсан "Цалин хөлсний тухай журам"-ын 3.3.7 "...Үйлдвэрийн газрын захиралтай Нэмэгдлийн гэрээ байгуулсан ажилтны нэмэгдэл цалинг үйлдвэрийн газарт ур чадвар, нарийн мэргэшил, мэргэжил шаардсан ажлын байранд мэргэжилтэнд нэмэгдэл цалин олгох", Монголросцветмет ТӨҮГ-ын захирлын ТӨБЗГ-тай байгуулсан контракт гэрээний 9-д "Ажил олгогчийн эрх үүрэг" гэж заасныг тус тус хэрэгжүүлээгүй байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1 "Шалгагдагч этгээд хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн, хуулиар хүлээсэн албан үүргээ биелүүлээгүй бол алдаа, зөрчлийг таслан зогсоох, давтан гаргуулахгүй байх талаар байгууллага, албан тушаалтанд албан шаардлага өгнө", Монгол Улсын Ерөнхий Аудиторын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох журмын 4.2.1-т заасныг үндэслэн **ШААРДАХ** нь:

1. Холбогдох хууль тогтоомж болон цалин хөлсний журмыг мөрдөн ажиллаж, зөрчлийг арилган, албан шаардлагын биелэлтийг 2022 оны 9 дүгээр сарын 30-ны өдрийн дотор Үндэсний аудитын газарт ирүүлэх;
2. Цаашид алдаа, зөрчлийг давтан гаргахгүй байх, хууль тогтоомжийг хэрэгжүүлж ажиллахыг Монголросцветмет ТӨҮГ-ын захирал Б.Мөнхбат, ерөнхий нягтлан бодогч Б.Цэнд-Аюуш нарт даалгав.

АЛБАН ШААРДЛАГА ӨГСӨН:

АУДИТЫН ХОЁРДУГААР ГАЗРЫН
ЗАХИРАЛ ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР
АУДИТЫН МЕНЕЖЕР
АУДИТОР
АУДИТОР

Ц.НАРАНЧИМЭГ
Д.ЭНХДАЛАЙ
М.ЛХАГВАСҮРЭН
О.БАЯРМАА

Монгол Улс Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг 7-р хороо, Бага тойруу-3, Засгийн газрын 4 дүгээр байр, Утас 51-204230

9019120 \00.10.10.20\Bichig 1\reg\Alban Shoardlaga\2022\0315 Auditin 2 Gasar-147.Docx

0001081288

ТЭМДЭГЛЭЛ

Dotted lines for writing.